



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

БАЯНТЭС СУМЫН СОНГУУЛИЙН
ХОРООНД

2024.08.19

№

451

танай

-ны №

-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Орон нутгийн Хурлын ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн бие даан нэр дэвшигч иргэн Г.Оюундарийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1: 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6: 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8: 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Ганбат овогтой Оюундарийн Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого,


төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Г.Оюундарийн мөрийн хөтөлбөр (....6..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Г.Оюундарь-д

Хавсралт ..6... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ – НИЙГМИЙН БОДЛОГО

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

1.1.1 Орон нутгийн эмч, эмнэлгийн ажилтнуудын хүрэлцээ хангамж ур чадварыг сайжруулан, эмчилгээ оношилгооны дэвшилтэд технологи, арга барилыг нэвтрүүлэн эмнэлгийн ажилтан мэргэжилтнүүдийг тогтмол сургалтад хамруулж чадвавхжуулах бодлогыг дэмжин ажиллана.

1.1.2 Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн үйлчилгээг сайжруулж явуулын амбулатори, үзлэг, оношилгоог жил бүр үе шаттайгаар зохион байгуулах бодлого боловсруулан ажиллана.

1.1.3 Орон нутгийн онцлогт тулгуурлан эмчилгээ, сувилал, амралтын газар байгуулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, уламжлалт эмнэлгийн үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.

1.1.4 Эмнэлгийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, иргэдэд эмнэлгийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх асуудлыг цогцоор нь үе шаттайгаар шийдвэрлэх бодлого боловсруулан ажиллана.

1.2 БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

1.2.1 Бүх нийтийн боловсролын төвшинг дээшлүүлэн, хичээлийн байр болон дотуур байр, цэцэрлэгийн орчин нөхцөлийг сайжруулж, сургалтын материаллаг бааз, тоног төхөөрөмжөөр хангагдсан, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий сургалтын орчин бий болоход дэмжлэг үзүүлэн ажиллана.

1.2.2 Нийт боловсролын байгууллагын багш, сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтын шинэ дэвшилтэд арга барилуудыг нэвтрүүлэх үүднээс шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний цогц бодлогыг хэрэгжүүлэн төрөл бүрийн сургалтад хамруулан бодлого боловсруулан ажиллана.

1.2.3 Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгон хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, ажлыг эрчимжүүлж, чийрэгжүүлэх танхимыг сумын төв, байгууллагуудад зохистой хэлбэрээр бий болгон хөгжүүлж, хүн амын дундаж наслалтыг улсын дундаж түвшинд хүргэх нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.

1.2.4 Орон нутагт хөгжүүлэх боломжтой зарим нэр төрлийн спортыг бодлогын хэмжээнд дэмжиж аймаг, улс бүсийн аваргыг сум орон нутгуудаас төрүүлэх арга хэмжээг дэмжиж ажиллана.

1.2.5 Хүүхэд залуучуудыг үндэсний спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэн, амжилт гаргасан тамирчдыг дэмжиж, үндэсний спортын холбоодтой хамтран ажиллана.

1.2.6 Соёлын биет болон биет бус өвийг хадгалах, өвлүүлэх олны хүртээл болгох чиглэлээр хийгдсэн ажлуудыг бататгаж, бүртгэлжүүлэх, томоохон хэмжээний зан заншил соёлын өв тээгчдийг илрүүлэн урамшуулах бодлого боловсруулан ажиллана.

2024 оны аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Ганбат овогтой Оюундарь /ИБ89111303/ мөрийн хөтөлбөр

- 1.2.7 Нийгмийн эмзэг бүлэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг шийдвэрлэх цогц бодлогыг дэмжин ажиллана.

1.3 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

- 1.3.1 Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй уялдуулан ажлын байрыг тууштай нэмэгдүүлж, ажилгүйдлийн төвшинг багасган, өрхийн амьжиргааг дэмжих бодлого боловсруулан ажиллана.

- 1.3.2 Ажлын байр шинээр бий болгож буй аж ахуйн нэгж, байгууллагыг бүх түвшинд орон нутгийн бодлогоор дэмжинэ.

- 1.3.3 Байгаль орчныг хамгаалах, бүтээн байгуулалт, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт үйлчилгээний ажилд амьжиргааны баталгаажих төвшингээс доогуур орлоготой иргэдийг өргөнөөр татан оролцуулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх бодлого боловсруулан ажиллана.

- 1.3.4 Малчдын нийгмийн хамгааллын талаар шинэ санаачлага гаргаж, залуу малчдыг бүх талаар дэмжиж ажиллана.

- 1.3.5 Бүх шатны төсвийн байгууллагын ажилчдыг урамшуулах шинэ санал санаачилгыг дэмжиж, сайн туршлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллана.

1.4 ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, АХМАД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

- 1.4.1 Хүүхэд, залуучуудын хэрэгцээ шаардлагад суурилсан, сурч боловсрох, хөгжих, соёл хүмүүжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн бодлого боловсруулан ажиллана.

- 1.4.2 хүүхэд, залуучууд, ахмад настан, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн Олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрүүдийг орон нутагтаа татах бодлого боловсруулан ажиллана.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

2.1 МАЛ, АЖ АХУЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.1.1 Мал эмнэлгийн байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулж, малын эмч мэргэжилтнийг чадавхжуулж, мал эмнэлгийн үзлэг оношилгоо, зоо мал эмнэлгийн арга хэмжээг эрчимжүүлж, малыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж, малын түүхий эд махны чанар стандартыг сайжруулахад тусгайлсан арга хэмжээ авах бодлогыг дэмжин ажиллана.

- 2.1.2 Мал, малын гаралтай бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтийг хурдасгах, Орон нутгийн эдийн засгийг тэлэх бодлогыг баримтлах замаар малчдын амьжиргаа, орлогыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэнэ ажиллана.

- 2.1.3 Мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах цогц бодлогыг дэмжин ажиллана.

2024 оны аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Ганбат овогтой Оюундарь /ИБ89111303/ мөрийн хөтөлбөр

2.1.4 Бэлчээр хамгаалах тал дээр санал санаачлага гаргаж ажиллана.

2.1.5 Малын сүргийн бүтцийг чанаржуулах бодлого хэрэгжүүлэн ажиллана.

2.1.6 Малчдаа дэмжих орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, ахмад үеийн улс, аймаг, сумын сайн малчдын туршлага, мал маллах арга ухааныг залуу малчдад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж, хариуцлагатай, чинээлэг малчин хөтөлбөрийг дэмжих бодлого боловсруулан ажиллана.

2.2 ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Газар тариалангийн бүс нутгийг шинэчлэн тогтоож орон нутагтаа малын тэжээлийн ургамал, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж орон нутгийн иргэд аж ахуйн нэгжийн хэрэгцээг хангах бодлогыг дэмжиж ажиллана.

2.2.2 Тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн техник, технологийн хангамжийг сайжруулж, хүнсний ногоо хадгалах зоорийг нэмэгдүүлж, хүлэмжийн аж ахуй, усалгаатай тариалан эрхлэгч, жимс жимсгэнэ, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжиж нэгжээс авах ургацын хэмжээг дээшлүүлэх бодлого боловсруулж ажиллана.

2.2.3 Бүх төрлийн тариалалтыг орон нутгийн бодлогоор дэмжин ажиллана.

2.3 БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

2.3.1 Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин эдийн засгийн таатай орчин бүрдүүлж, төрийн байгууллагын хууль бус дарамт шахалтыг арилгана.

2.3.2 Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрүүдэд хамруулж, ажлын үр өгөөж хүртээмжийг дээшлүүлэх бодлого боловсруулж ажиллана.

2.3.3 Жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад зах зээлд гаргах, хил орчмын худалдаанд идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлж ажиллана.

2.3.4 Орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдэд тавих хяналтыг нэмэгдүүлж, хэрэгжилтийг ханган иргэдэд төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг нээлттэй ил тод болгоно.

2.3.5 Олон улсын болон орон нутгийн төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулна.

2.4 АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.4.1 Үйлдвэрлэл худалдаа эрхлэгчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, орон нутагт ажлын байр шинээр бий болгох ажил үйлчилгээг бодлогоор дэмжинэ.

2.4.2 Нөхөрлөл хоршоо, аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж хамтран

2024 оны аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Ганбат овогтой Оюундарь /ИБ89111303/ мөрийн хөтөлбөр

ажиллах замаар шинэ ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого боловсруулж ажиллана.

2.4.3 Орон нутагт хэрэгжих томоохон төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж хамтран ажиллах замаар ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого боловсруулж ажиллана.

2.4.4 Хоршоо болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, орон нутагт хөгжлийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бодлого боловсруулан ажиллана.

2.5 ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР

2.5.1 Орон нутгийн төсвийн орлогын бүрдэлт, зарцуулалтын харилцааг төрийн бодлогод уялдуулан оновчтой төлөвлөж, хэрэгжилтийг сайжруулж, эдийн засгийн хэмнэлттэй, ашигтай төсөв санхүүгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.5.2 Орон нутгийн өмч ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.

2.5.3 Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх бодлого баримтална.

2.5.4 Орон нутагт хэрэгжиж байгаа сангуудын зарцуулалтыг үр дүнтэй, иргэдэд нээлттэй ил тод болгох, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.

ГУРАВ. ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО

3.1 Хэрэглэгч аймгаас үйлдвэрлэгч аймагт шилжих зорилтыг эрчимжүүлж орон нутгийн нөөц боломжид тулгуурлан үйлдвэрлэгч аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.

3.2 Аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шаардлагатай арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж ажиллана.

3.3 Аялал жуулчлалыг дагасан үйлдвэрлэл, үйлчилгээг бүх чиглэлээр хөгжүүлэх арга хэмжээ авна.

3.4 Орчин үеийн шинэлэг техник технологит тулгуурлан хот төлөвлөлт, дахин төлөвлөлтийг хийж хэрэгжилтийг зохион байгуулж, Амины орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого боловсруулан ажиллана.

3.5 Улс, аймаг, сум хоорондын авто замын сүлжээг сайжруулж, авто зам гүүрний байгууламж барих засварлах ажлыг эрчимжүүлэхэд санаачлага гарган ажиллана.

3.6 Гадаадын төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах боломжийг судалж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд бодлого боловсруулан ажиллана.

3.7 Эрчим хүчний салбарын цахилгаан, дулаан үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үүднээс байгалийн нөөц боломжийг ашиглан усан болон нарны эрчим хүчийг нэмэгдүүлэх талаар судалгаа шинжилгээ хийж хэрэглэгчдийн цахилгаан дулааны хэрэглээний ухаалаг үнийн систем нэвтрүүлэх бодлого боловсруулан ажиллана.

3.8 Төсвийн хөрөнгө оруулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлэн хэрэгжилтийг зохион

2024 оны аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Ганбат овогтой Оюундарь /ИБ89111303/ мөрийн хөтөлбөр

байгуулна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН - АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

- 4.1 Онгон байгалиа хамгаалах чиглэлээр цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2 Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 4.3 Улс болон орон нутгийн тусгай хамгаалалтыг нэмэгдүүлж, шаардлагатай арга хэмжээг үе шадтай авч хэрэгжүүлнэ.
- 4.4 Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг боловсруулж, Цөлжилттэй тэмцэх шинэ технологи нэвтрүүлж, олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.
- 4.5 Уул уурхайн лиценз нэмж олгохгүй, тоог цөөлж уул уурхайгүй аймаг болно.
- 4.6 Байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалах чиглэлээр хүүхэд, залууст зориулсан эко боловсролын тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, тэдгээрийн байгаль хамгаалах санал санаачилга, сайн дурын хөдөлгөөнийг урамшуулах бодлого боловсруулан ажиллана.
- 4.7 Баялгийн зөв зохистой ашиглах нөхцөлийг хангаж, ашиглалт, хэрэгжилтийн явцад иргэдийн оролцоог хангахад дэмжлэг үзүүлэн ажиллана.

ТАВ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО - ЗӨВ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 5.1 Төрийн албаны томилгоонд шударга зарчмыг бүрэн хэрэгжүүлнэ.
- 5.2 Төрийн албан хаагчдыг давтан сургалтад хамруулж чадавхжуулна.
- 5.3 Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, жил бүр нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулна.
- 5.4 Тулгамдсан, нэн шаардлагатай зорилтуудыг олж тодорхойлох, тэдгээрийг шийдвэрт тусгаж хэрэгжүүлэх, шаардлагатай асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг болно.
- 5.5 Төрийн ажил үйлчилгээг иргэдэд нээлттэй хөнгөн шуурхай, чирэгдэл, хүндрэлгүй хүргэх бүх нөхцөл шаардлагыг аймаг, сумын түвшинд жигд хэрэгжүүлнэ.
- 5.6 Иргэдээ сонсох уулзалт ярилцлагыг тогтмол хийж, нээлттэй утсыг байнга ажиллуулж, санал гомдлын мөрөөр бодит ажил зохиож үр дүнг мэдэгдэж хэвшинэ.
- 5.7 Улаанбаатар хот болон бусад аймаг хотуудад байгаа нутгийн зөвлөлүүд, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудтай харилцан хамтран ажиллаж, тэдгээрийн орон нутгаа хөгжүүлэх аливаа үйл ажиллагааг онцгойлон анхаарч дэмжиж ажиллана.

2024 оны аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Ганбат овогтой Оюундарь /ИБ89111303/ мөрийн хөтөлбөр

- 5.8 Авлигын эсрэг төрөөс баримталж байгаа бодлогыг бүх шатандаа бүрэн хэрэгжүүлж ажиллана.
- 5.9 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлыг дэмжиж шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь хэрэгжүүлж ажиллана.

Мөрийн хөтөлбөр¹ бэлтгэсэн:

Бие даан нэр дэвшигч:

J. Ovington

Г.Оюундарь /Утас98509099/

2024 оны 07 сарын 24 өдөр